

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/012/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Алтай хот	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
	Аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Гурав. Аудитын илрүүлэлт

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 25 № 152

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бигэр сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татвар 12.7 сая төгрөгөөр, шууд бус орлого 11.5 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 1.3 сая төгрөгөөр тус тус тасарсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөөс 11.1 сая төгрөгийг тэмээний баяр, мал аж ахуй, газар тариалангийн салбарт үр бүтээлтэй ажилласан иргэдэд хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгал, шагналд, 17.0 сая төгрөгийг БНХАУ-ын Ганьсу муж, Шинжан Уйгар мужуудад тэмээчдийн аж ахуйтай танилцах, туршлага судлах зардалд, 1.5 сая төгрөгийг хүүхдийн гэр зуслангийн үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулж, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумд 1.0 сая төгрөгийн хандив тусламжийг үзүүлсэн,

- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 129.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, "Сумын 2025 оны төсөв тодотгон батлах тухай" Бигэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 604.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 622.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 18.1 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,351.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байхад бэлэг дурсгал, шагнал, хандив, туршлага судлах арга хэмжээнд төсөв зарцуулсан.

Сумын төсвийн байгууллагуудын тогтмол зардлыг 899.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 267.6 сая төгрөг зарцуулж, 631.9 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн нь тогтмол зардлыг үндэслэлгүй хэт өндөр дүнгээр төлөвлөсөн байна.

Тус сумд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан халаалтын зуух тайлант онд ашиглалтад орж, Говийн гал голомт ХХК нь дулаан үйлдвэрлэх, түгээх тусгай зөвшөөрөлгүй боловч төсвийн байгууллагуудтай гэрээ байгуулж, дулаанаар хангах үйл ажиллагааг явуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 31 зорилт, 95 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 86.3 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,113,012.2	1,913,289.6
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	500,627.7	1,129,602.9
3	АВЛАГА	253,729.9	212,015.9
4	БАРАА МАТЕРИАЛ	130,481.0	135,995.2
5	НӨӨЦИЙН БАРАА	19,233.6	28,255.6
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	208,940.0	407,420.0
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,045,740.1	2,942,643.7
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,045,740.1	2,942,643.7
9	Биет хөрөнгө	2,973,829.7	2,871,503.4
10	Биет бус хөрөнгө	71,910.3	71,140.3
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,158,752.3	4,855,933.3
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	140,826.0	47,886.2
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	140,826.0	47,886.2
14	Өглөг	140,826.0	47,886.2
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,017,926.2	4,808,047.1
16	Засгийн газрын хувь оролцоо	4,017,926.2	4,808,047.1
17	Засгийн газрын оруулсан капитал	265,296.2	265,296.2
18	Хуримтлагдсан үр дүн	3,456,901.0	4,247,047.0
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	295,729.0	295,703.9
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,158,752.3	4,855,933.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,566,810.7	2,675,186.3
2	ТАТВАРЫН ОРЛОГО	540,108.6	541,111.1
3	Орлогын албан татвар	501,636.7	454,626.7
4	Хувь хүний орлогын албан татвар	526,020.9	476,961.3
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,384.13)	(22,334.6)
6	Хөрөнгийн албан татвар	27,756.6	53,410.4

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

7	Бусад татвар, төлбөр, хураамж	10,715.3	33,074.0
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	486,274.1	2,134,075.2
9	Тусламжийн орлого	-	1,359,699.2
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,540,428.1	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,913,381.0	1,776,612.0
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,913,381.0	1,776,612.0
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,800,575.5	1,720,776.4
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	757,284.1	783,373.5
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,795.2	96,764.9
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,515.9	268,295.6
17	Хангамж, бараа материалын зардал	83,731.3	20,232.7
18	Эд хогшил, урсгал засварын зардал	28,135.8	43.0
19	Томилолт, зочны зардал	9,782.0	20,170.0
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,345.3	3,138.4
21	Бараа үйлчилгээний бусад зардал	702,986.1	528,758.5
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,805.4	55,835.6
23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	653,429.8	898,574.2
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	101,337.0	108,453.3
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(101,337.0)	(108,453.3)
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	552,092.8	790,120.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,445,833.4	3,445,833.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,000.0	20,000.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,465,833.4	3,465,833.4
4	Тайлант үеийн үр дүн	552,092.8	552,092.8
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,017,926.2	4,017,926.2
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,017,926.2	4,017,926.2
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25.1	25.1
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,017,951.4	4,017,951.4
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(25.1)	(25.1)

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

10	Тайлант үеийн үр дүн	790,120.9	790,120.9
11	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,808,047.1	4,808,047.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,273,852.5	2,397,587.9
2	ТАТВАРЫН ОРЛОГО	540,108.6	541,111.1
3	Орлогын албан татвар	501,636.7	454,626.7
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,384.1)	(22,334.6)
5	Хөрөнгийн албан татвар	27,756.6	53,410.4
6	Бусад татвар, төлбөр, хураамж	10,715.3	33,074.0
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,771.4	5,037.4
8	Газрын төлбөр	6,907.7	7,609.8
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	36.2	20,426.8
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193,315.8	1,856,476.9
11	Нийтлэг татварын бус орлого	193,315.8	89,316.7
12	Тусламжийн орлого	-	1,359,699.2
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	407,461.0
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,540,428.1	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,479,976.4	1,399,469.7
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,479,976.4	1,399,469.7
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,367,171.0	1,343,634.1
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	756,775.2	786,271.6
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,050.1	93,866.7
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,515.9	268,295.6
21	Хангамж, бараа материалын зардал	26,325.4	18,488.7
22	Эд хогшил, урсгал засварын зардал	26,665.8	-
23	Томилолт, зочны зардал	9,782.0	12,670.0
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,345.3	2,954.4
25	Бараа үйлчилгээний бусад зардал	328,711.4	161,087.2
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,805.4	55,835.6
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	793,876.1	998,118.3

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	627,359.5	369,143.1
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	627,359.5	369,143.1
30	Дотоод эх үүсвэрээр	627,359.5	369,143.1
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(627,359.5)	(369,143.1)
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,000.0	-
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(35,000.0)	-
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	131,516.6	628,975.2
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	369,111.1	500,627.7
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	500,627.7	1,129,602.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

З	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦЭВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,700,424.9	2,381,712.3	318,712.6	88.2
11	Татварын орлого	546,896.5	541,111.1	5,785.4	98.9
110	Орлогын албан татвар	447,543.7	454,626.7	(7,083.0)	101.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	469,878.3	476,961.3	(7,083.0)	101.5
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	357,233.9	368,321.6	(11,087.7)	103.1
110002	Үйл ажиллагааны орлого	9,528.6	8,192.0	1,336.6	86.0
110003	Хөрөнгийн орлого	49,489.1	56,151.8	(6,662.7)	113.5
110004	Хөрөнгө борлуулсны орлого	-	2,140.0	(2,140.0)	
110008	Шууд бус орлого	53,626.7	42,155.9	11,470.8	78.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(22,334.6)	(22,334.6)	(0.0)	100.0
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(22,334.6)	(22,334.6)	(0.0)	100.0
113	Хөрөнгийн албан татвар	68,072.2	53,410.4	14,661.8	78.5
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	7,050.4	13,253.7	(6,203.3)	188.0
113002	Бууны албан татвар	2,930.0	3,431.2	(501.2)	117.1
113004	Малд ногдуулах албан татвар	58,091.8	36,725.5	21,366.3	63.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	31,280.6	33,073.9	(1,793.3)	105.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,417.1	5,037.4	(2,620.3)	208.4
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,417.1	4,037.4	(1,620.3)	167.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	-	1,000.0	(1,000.0)	
1181	Газрын төлбөр	7,000.0	7,609.8	(609.8)	108.7
118101	Газрын төлбөр	7,000.0	7,609.8	(609.8)	108.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,863.5	20,426.8	1,436.7	93.4
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	20,592.0	18,685.3	1,906.7	90.7

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,271.5	1,741.5	(470.0)	137.0
12	Татварын бус орлого	2,153,528.4	1,840,601.3	312,927.1	85.5
120	Нийтлэг татварын бус орлого	57,680.8	81,566.6	(23,885.8)	141.4
120003	Торгуулийн орлого	2,695.8	3,777.4	(1,081.6)	140.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	52,831.3	73,471.9	(20,640.6)	139.1
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	2,153.7	4,317.3	(2,163.6)	200.5
122	Тусламжийн орлого	1,684,270.8	1,351,573.6	332,697.2	80.2
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,351,573.6	1,351,573.6	-	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	332,697.2	-	332,697.2	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	411,576.8	407,461.0	4,115.8	99.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	411,576.8	407,461.0	4,115.8	99.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,700,424.9	1,633,290.7	1,067,134.2	60.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,968,327.6	1,276,347.7	691,979.9	64.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,904,712.0	1,220,512.1	684,199.9	64.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794,231.0	782,847.7	11,383.3	98.6
210101	Үндсэн цалин	337,645.0	334,802.9	2,842.1	99.2
210102	Нэмэгдэл	328,615.1	323,270.7	5,344.4	98.4
210104	Урамшуулал	38,173.7	35,810.4	2,363.3	93.8
210105	Гэрээт ажлын хөлс	89,797.2	88,963.7	833.5	99.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,215.5	93,804.2	5,411.3	94.5
210201	Тэтгэврийн даатгал	67,462.4	63,694.8	3,767.6	94.4
210202	Тэтгэмжийн даатгал	7,938.3	7,701.9	236.4	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,969.1	3,948.7	20.4	99.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,969.1	3,679.0	290.1	92.7
210205	Эрүүл мэндийн даатгал	15,876.6	14,779.7	1,096.9	93.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	899,473.2	267,574.4	631,898.8	29.7
210301	Гэрэл, цахилгаан	67,000.0	45,356.4	21,643.6	67.7
210302	Түлш, халаалт	822,586.0	220,001.8	602,584.2	26.7
210303	Цэвэр, бохир ус	9,887.2	2,216.2	7,671.0	22.4
2104	Хангамж, бараа материалын зардал	25,558.4	16,621.3	8,937.1	65.0
210401	Бичиг хэрэг	6,835.0	4,021.8	2,813.2	58.8
210402	Тээвэр, шатахуун	14,604.4	11,367.1	3,237.3	77.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,225.0	920.2	1,304.8	41.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100.0	35.2	64.8	35.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,794.0	277.0	1,517.0	15.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,900.0	-	6,900.0	0.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,900.0	-	6,900.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	22,959.0	12,670.0	10,289.0	55.2
210702	Дотоод албан томилолт	22,959.0	12,670.0	10,289.0	55.2

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,210.8	3,164.4	1,046.4	75.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	440.0	330.0	110.0	75.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604.8	302.4	302.4	50.0
210803	Даатгалын үйлчилгээ	315.0	221.7	93.3	70.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347.6	306.6	41.0	88.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154.0	141.0	13.0	91.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.0	290.0	160.0	64.4
210807	Газрын төлбөр	746.4	684.8	61.6	91.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,153.0	888.0	265.0	77.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,164.1	43,830.1	8,334.0	84.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,164.1	42,720.1	6,444.0	86.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.0	1,110.0	1,890.0	37.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,615.6	55,835.6	7,780.0	87.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,615.6	55,835.6	7,780.0	87.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,515.6	29,515.6	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,100.0	26,320.0	7,780.0	77.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	655,885.3	356,943.1	298,942.2	54.4
223001	Бусад хөрөнгө	655,885.3	356,943.1	298,942.2	54.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	76,212.0	-	76,212.0	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	76,212.0	-	76,212.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	359,924.7		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,095,499.9		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	52,308.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,308.0
122	Тусламжийн орлого	52,308.0
1221	Хандив тусламж /дотоод/	52,308.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,308.0
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,845.6
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,462.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,972.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,972.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,972.0

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,423.9
210101	Үндсэн цалин	3,423.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62.5
210201	Тэтгэврийн даатгал	62.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	721.2
210301	Гэрэл, цахилгаан	721.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,867.4
210402	Тээвэр, шатахуун	1,717.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,897.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,897.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	31,335.9

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, БХНСС, ОНХС, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1 Харьяа байгууллага

3.1.1 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 0.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 1 алдааг залруулж, 73.3 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлж, 1.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 71.5 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, БХНСС, ОНХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл, тайлагналтай холбоотой 54.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулж, 10.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 45.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт: 5.1

Аудитаар 44.2 сая төгрөгийн бүртгэл тайлагналын 1 алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 58.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчил арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлж байна.

Залруулагдаагүй нийт 58.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинөөс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 66.9 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.3 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 129.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 11.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 71.5 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 45.7 сая төгрөгийн зөвлөмж холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлого 1.3 сая төгрөгөөр, шууд бус орлого 11.5 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 12.7 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Бигэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоол "Сумын 2025 оны төсөв тодотгон батлах тухай"-тай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах.

2. **Арвиан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой**

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2025 оны тэмээний баяр, мал аж ахуй, газар тариалангийн салбарт үр бүтээлтэй ажилласан иргэдэд хүндэтгэл үзүүлэхэд бэлэг дурсгал, шагналд 11.1 сая төгрөг, БНХАУ-ын Ганьсү муж, Шинжан Уйгар мужуудад тэмээчдийн аж ахуйтай танилцах, туршлага судлах зардалд 17.0 сая төгрөг, хүүхдийн гэр зуслангийн үйл ажиллагаанд 1.5 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумд 1.0 сая төгрөгийн хандив тусламжийг үзүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 -ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардалд зарцуулахгүй байх.

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Бигэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

						1												
Бигэр сумын ХХС	1	-	-	-	-	1	1	10,408.9	1	10,408.9					-	-	-	-
Дүн	6	1	1			4	9	187,033.7	2	11,777.3	3	71,542.5	4	103,713.9	-	-	-	-